



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/236

Есөнбулаг сум

Баруун бүсийн сургалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалт, Эрүүл мэндийн тухай 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.7, 11.1.8 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.2 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд "Хүүхдийн өвчний цогц менежментээс хүүхдийн эрчимт эмчилгээ" сэргээн бэхжүүлэх, гүнзгийрүүлэн дээшлүүлэх баруун бүсийн сургалтыг 2026 оны 5 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтад хамрагдах, туршлага солилцох эмч, мэргэжилтний сургалтын зардалд шаардагдах 6,000,000 (Зургаан сая) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

